

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Математикийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Дашхүү Отгонтуяа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх.							
1	Математикийн багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үндсэн сургалт зохион байгуулах.	Сургалтад хамрагдсан багшийн тоо, хувь	Үндсэн сургалтад хамрагдсан нийт математикийн багш - 466	480, 80%	Багшийн МДҮС танхим-цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд танхимын сургалт 16 цагаар цахим сургалт 40 цагаар төлөвлөгдөж хэрэгжсэн. Цахим сургалт 2025 оны 03 сарын 24-ний өдрөөс 05 сарын 09-ний өдрийг дуустал хугацаанд амжилттай зохион байгуулагдлаа. Математикийн багшийн цахим сургалтад ЕБС-д 5, 10, 15, 20 дахь жилдээ ажиллаж байгаа математикийн 297 багш хамрагдах ёстойгоос 289 багш буюу 97.3 хувьтай оролцлоо. Эдгээрээс 228 багш нь буюу 76.4 хувь нь амжилттай суралцаж батламжаа гардан авсан. Танхимын сургалтыг Хөвсгөл, Орхон, Булган, Баянгол дүүрэгт зохион байгуулсан. Сургалтын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					агуулга үндсэн 3 чиглэл: 1. Эргэцүүлэл 2. Багшийн цахим ур чадвар 3. Хичээлийн судалгаа нийт 40 цагаар төлөвлөж хэрэгжүүлсэн нь математикийн багш нарын хэрэгцээнд нийцсэн байдал нь сургалтын дараах “санал асуулга” аргаар авсан судалгаанаас тодорхой харагдаж байна. 3.2 Цаашид анхаарах зүйл, сайжруулах санал Цахим сургалтын талбар bagsh.edu.mn болон Моза платформд -т нэвтрэхэд дараах асуудлууд гарч байна. • МДҮС 2025 сонголт гарч ирэхгүй байх • Мэдлэ болон мөс хаяг нь нэр болон нууц үг нь буруу гээд орохгүй байх • Мөсөөр класрууд орохоор нэмэлт цэс нь гарч ирэхгүй байх • Хувийн сургуулийн багш нарт класрууд дээр нэмэлт цэс гарахгүй байх • Мозавэб дээр шинэ хэрэглэгчээр нэвтрэхэд багш гэдэг сонголт нь гарч ирэхгүй байх гэх мэт асуудлууд тохиолдож байсан. • Талбарт багш нар давхар нэвтрэх • Өөр судлагдахууны багш нар талбарт нэвтрэх Хавсралт: 4 файл		
2	Багшийн хөгжлийг дэмжих платформд суурилсан цахим сургалтын сан	Платформд байршуулсан шаардлага хангасан цахим	0	12, 50%	Сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан өөрсдийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн цаг хугацаа, орон зайнаас үл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 10-р	90%

	бүрдүүлэхэд хамтран ажиллах	сургалтын тоо, чанар			хамааран суралцах боломж бий болгох зорилт тавин ажиллаж байна.Багшийн хөгжлийг дэмжих Bagsh.edu.mn платформ суурилан суралцах боломжтой болж байна.Боловсролын ерөнхий газраас 2023-2024 онд зохион байгуулсан модуль сургалтын үр дүнгийн судалгаа, мониторингоос багш нараас хамгийн өндөр үнэлгээ авсан 12 модулийг сонгож, боловсруулсан багтай гэрээ байгуулан БЕГ-ын өмчид авсан.Манай байгууллага гэрээний дагуу тус 12 модулийг ашиглан сургалт зохион байгуулах эрхтэй. Багшийн хөгжлийн Bagsh.edu.mn платформд 12 модулийг байршуулсан бөгөөд багш нар сонголтоороо үнэ төлбөргүй судалж, амжилттай төгсвөл батламж авах боломжийг бүрдүүлсэн. Математикийн багш нарт зориулсан "Магадлал, статистик сэдвийн арга зүйн хөгжүүлэлт /суурь боловсролын түвшинд" сэдэвт онлайн сургалтын модулийг цахим талбарт байршуулсан болно. Хавсралт: 2 файл	сар, 11-р сар, 12-р сар	
3	Багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах	Хөтөлбөрийн батлагдсан удирдамж, төлөвлөгөө, оролцогчдын тоо, чанар	Сургалтын байгууллага-15, багш -20	24, 100%	2 дугаар хагаст хэрэгжүүлнэ.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-	0%

						р сар, 12-р сар	
4	Сургалтын байгууллагын “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, үндэсний хэмжээнд онол практикийн бага хурал зохион байгуулах, сайн туршлага бүхий МХБ-ийн сан бүрдүүлэхэд хамтран ажиллах	Зөвлөн тусалсан МХБ-ийн тоо, сайн туршлага бүхий МХБ-ийн тоо	Сургалтын байгууллага дээр 3800 МХБ ажиллаж байна. Сайн туршлага бүхий 15 МХБ-ийн сан бүрдсэн.	116 / 12, 50%	1. Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт, түүний нөхцөл байдлыг илрүүлэх судалгааны ажлыг зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна. “Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам” – ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлын чиглэл Зорилго: Мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх/нөхцөл байдлыг илрүүлэх, зөвлөн туслах Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 1. Сургуулийн захиралтай ярилцлага хийх 2. Багшийн хөгжлийн менежертэй ярилцлага хийх 3. Багшийн хөгжлийн төвийн нэгдсэн төлөвлөгөөтэй танилцах/Мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаа тусгагдсан байдал/ 4. Мэргэжлийн багш нарын бүлэг /Суралцахуйд суурилсан - тэгш хамруулан сургах арга зүй, хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр байгуулагдсан МББ/-ийн мэдээлэл илрүүлэх 5. Мэргэжлийн багш нарын бүлэг /Судлагдахууны чиглэлээр байгуулагдсан МББ/-ийн	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

						мэдээлэл илрүүлэх 6. Сайн туршлагын мэдээлэл илрүүлэх – загвар боловсруулах 2. Багшийн хөгжлийн зардлын зарцуулалтын талаар Завхан аймгийн Жавхлант сургууль дээр ажилласан тайлан гаргасан. Хавсралт: 2 файл		
5	Хамтын ажиллагаа, санамж бичгийн хүрээнд Солонгос-Монгол багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд манлайлалтай ажиллах	Туршлага солилцсон багш, мэргэжилтний тоо, үр дүн	10 багш, мэргэжилтэн хамрагдсан.	2	10, 70%	2 дугаар хагаст хэрэгжинэ.	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	90%
6	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахад хамтран ажиллах	Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө оролцогчдын тоо, хувь	0		650, 70%	Ерөнхий боловсролын сургуулиудын багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, чадавхжуулах сургалтын хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлж ажилласан. Зорилт: • Багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, чадавхжуулах. • Сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийг бэхжүүлэх хүний нөөцийг хөгжлийг дэмжих. Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, МУБИС-ийн дэргэдэх Багшийн хөгжлийн үндэсний төв байгууллагууд хамтран зохион байгуулсан. Сургалт зохион байгуулсан хугацаа: 2025 оны 04	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					дүгээр сарын 24, 25 Орон нутаг: Архангай аймаг Хамрагдсан хүрээ: Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежер 28, Боловсролын газрын мэргэжилтэн 5 нийт 33 хүн оролцсон. Сургалтыг багш Г.Чулуунаа /МУБИС/-тай хамтран зохион байгуулсан болно. Хавсралт: 3 файл		
7	Сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтаас бусад олон талт (төсөл, хөтөлбөр, зөвлөгөөн, түншлэл, эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал) үйл ажиллагаанд оролцох	Үйл ажиллагааны батлагдсан хөтөлбөр, удирдамж, оролцогчдын тоо, хувь	Сургалт-8, оролцогч-1211	5, 50%	1. Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн зэргийн материалыг уншиж, дүгнэлт, үнэлгээгээ хийсэн. Журамд заасан маягтын дагуу 8 багшийн тэргүүлэх зэргийн дүгнэлт гаргасан. Хариуцсан багш нарын дүгнэлтийг маягтын дагуу хийж, хуваарилагдсан мэргэжлийн боловсрол хариуцсан мэргэжилтнүүдэд хянуулж, хэвлэж, гарын үсэг зурж, БАБХГ-ын даргын гарын үсгээр баталгаажуулан ажлын хэсгийн нарийн бичиг Ж.Мөнхзулд хүлээлгэн өгсөн болно. Зэргийн дүгнэлтийг 2025 оны 5-р сарын 29-ний өдөр дуусгаж өгсөн. 2. БҮТ-тэй хамтран ажиллаж СӨБ ГҮ шалгалтыг Сэлэнгэ аймагт/04 сарын 28-05 сарын 02/, ЕБС-ийн ГҮ-ний шалгалтыг Баянхонгор аймагт 05 сарын 12-ны өдрөөс 05 сарын 23-ны өдрийг дуустал	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хугацаанд зохион байгуулах багийн ахлагчаар ажилласан. Хавсралт: 1 файл		
3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах							
8	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	биелэлт	100	50%	Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан. Тухайлбал: Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зураглал хийх удирдамжийн дагуу Баян-өлгий аймагт ажилласан. Зорилго нь туршилтын цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш нар болон орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн нартай менежментийн зураглал, төлөвлөгөөг хамтран боловсруулах Зорилт нь - Орон нутаг туршилтын сургууль, цэцэрлэгүүд шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх зураглал, төлөвлөгөө боловсруулах аргачилтай танилцан, зураглал, төлөвлөгөө гарсан байх - Орон нутгийн болон сургуулийн төлөвлөгөө, тайланг PDCA мөчлөгийн дагуу шинэчилсэн сургалтын хөтөлбөртэй уялдуулан боловсруулах аргачлалтай танилцах - Туршилтын сургууль, цэцэрлэгүүд шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг түгээн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					дэлгэрүүлэх зураглал, төлөвлөгөө боловсруулах - Орон нутгийн түвшинд шинэчилсэн СӨБ, Бага (1,2 анги) сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх зураглал, төлөвлөгөө боловсруулах Энэхүү ажлыг удирдамжид заасны дагуу Боловсролын газрын дарга, сургалт арга зүйн хэлтсийн дарга, бага боловсрол, СӨБ болон судлагдахуун хариуцсан мэргэжилтэн - 4 хүн, СӨБ хөтөлбөрийн туршилтыг хэрэгжүүлж буй цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, МХБ-ийн ахлагч багш - 4 хүн, Бага боловсролын хөтөлбөрийн туршилтыг хэрэгжүүлж буй сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежер, МХБ-ийн ахлагч багш - 4 хүн, Бусад сургуулийн удирдлага, МХБ-ийн төлөөлөл, зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй багш нарын төлөөлөл - 6 хүн, нийт 18 хүнийг хамруулан зохион байгуулсан. Хавсралт: 1 файл		
9	Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу	Биелэлт	100	50%	БАБХГ-ын эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулахад, холбогдох материалыг хүлээлгэн өгсөн. Үүнд: 1. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан 2. БАБХГ-аас	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	100%

	архивын нэгж болгон хадгалуулах				зохион байгуулсан үндсэн болон модуль сургалт, бусад сургалт зөвлөгөөн, багшийн мэргэжлийн зэрэг, нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлсэн зэрэг баримт		
10	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	Биелэлт	100	50%	Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг өдөр тутам хэрэгжүүлж ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах	Сургалт тус бүрийн зорилго зорилтын хүрэн дэх мэдлэг чадварыг эзэмшиж, үйл ажиллагаандаа	Сургалтад танхим болон онлайнаар хамрагддаг	Сургалтад танхим болон онлайнаар хамрагдсан байна.	Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдсан. Тухайлбал: - Нийгмийн даатгалын тухай хуулийн танилцуулга/2025	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

		тусган хэрэгжүүлнэ.			оны 05 сард - Санхүүгийн баримт бичиг бүрдүүлэхэд анхаарах зүйл/2025 оны 05 сард - Монгол бичгийн сургалт/ 2025 оны 01-05 сард	сар, 11-р сар, 12-р сар	
2	Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, шийдвэрийг судлах	Судалсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судална	Ажил үүргийн чиглэлд хамаарах шинээр батлагдсан бичиг баримтын сан үүсгэсэн байна. Шинээр батлагдсан бичиг баримтуудыг уншиж судалж хэвшсэн.	Ажил үүргийн чиглэлд хамаарах шинээр батлагдсан бичиг баримтын сан үүсгэсэн байна. Шинээр батлагдсан бичиг баримтуудыг уншиж судалсан байна.	Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судалж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тухайлбал: - МУ-ын БШУСайдын 2025 оны 01 сарын 22-ны өдрийн А/25 дугаар тушаал: Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам - МУ-ын Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 05 сарын 26-ны өдрийн А/127 дугаар тушаал: Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах журам - МУ-ын БШУСайдын 2024 оны 03 сарын 11-ний өдрийн А/115 дугаар тушаал: Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам - МУ-ын БШУСайдын 2024 оны 5 дугаар сарын 29-	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					ний өдрийн А/262 дугаар тушаал: Төрөлжсөн сургалт зохион байгуулах журам		
3	Монгол бичгийн мэдлэг, ур чадварыг дэмжих сургалт, үйл ажиллагаанд хамрагдах	Сургалт зохион байгуулах, дасгал ажлын дэвтэр дээр ажиллах	Хоёр удаагийн сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан.	Сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан байна.	Удирдлагын академийн "Монгол бичгийн мэдлэг, ур чадварыг дэмжих" онлайн сургалтад хамрагдаж, бие даан суралцаж байна. Мөн Англи хэлний мэдлэгээ тогтмол дээшлүүлж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Математикийн багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Дашхүү Отгонтуяа /...../

Огноо:

.....